



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар A/59

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
3. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2009” стандартын шаардлагыг хангасан, тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Блюскай эйжиа ХХК-ийн “Блю Скай Тауэр” зочид буудлын 18/303, Ундецим Ундецим ХХК-ийн “Жи” зочид буудлын 18/38, Бадман дэлгэрэх ХХК-ийн “Дэлгэрэх” зочид буудлын 18/273, Ашид инж ХХК-ийн “Ашид” зочид

**Боловсруулсан:** Ч. Ган-Огнол  
**Хянаасан:** Д. Тамгаев  
**Нийтийн:** Г. Батбаяр

буудлын 18/271, Уян хайрхан ХХК-ийн “Мерри” дэн буудлын 18/191 гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний чанар стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон /-д үүрэг болгосугай.

7. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг тухайн байгууллагаас хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцож/-д даалгасугай.



Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2019 оны 07  
сарын 22 өдрийн А/59 дугаар  
тушаалын Нэгдүгээр хавсралт

5284325 СБТ 48936 1118260502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

S

2019.07. 22

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Блюскай эйжия ХХК	5093171	Блю Скай Тауэр	СБД-ийн, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 17
2	Үндецим ундецим ХХК	5429552	Жи	ЧД-ийн, 4-р хороо, Самбуугийн гудамж 16/3
3	Бадман дэлгэрэх ХХК	5047242	Дэлгэрэх	БЗД-ийн, 13-р хороо, Алтан тэвш АОС-93 тоот
4	Ашид инж	5110076	Ашид	БГД-ийн, 12-р хороо, 6-р бичил хороолол Өргөө гудамж 7-н тоот

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2019 оны 07  
сарын 22 өдрийн А/59 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НӨРЖИЙН  
ЖАГСААЛТ

2019.07.22

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Уян хайрхан ХХК	2542838	Мерри	НД-ийн, 2-р хороо, Найрамдалын гудамж
2	Билгүүн лотус ХХК	5645719	Лотус	БЗД-ийн, 16-р хороо, 16- р хороолол 49-12 тоот
3	Босоо заяа ХХК	6404634	Окау	ЧД-ийн, 3-р хороо, 2-р 40 мянгатын 19 тоот

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2019 оны 07  
сарын 22 өдрийн А/59 дугаар  
тушаалын гуравдугаар хавсралт

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГДАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2019.07.22

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Гюүдон хаус ХХК	5659582	Жигүүр	НД-ийн, 6-р хороо, Горхи тэрэлжийн БЦГ-н Чингис уулын баруун талд
2	Чингис хааны хүрээ ХХК	5619661	Чигис хааны хүрээ	ХУД-ийн, 8-р хороо, Богд хаан уулын Жаргалантын ам

-ооОоо-